



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

**Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох,
сонсгол даргалагчийг томилох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшүүлсэнтэй холбогдуулан нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулахаар товлосугай.

2.Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарыг томилсугай.

3.Нэр дэвшигчийн сонсголын талаар нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангаж, холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо (Л.Энхнасан), мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар (Б.Баасандорж)-т тус тус даалгасугай.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Л.ЭНХНАСАН